



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн:
Утас: 70378845
Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Г.Батмягмар
Утас: 70373089
Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.11 № 33

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд давхардсан тоогоор 207 хоригдлыг ажлын байраар хангаснаар нийт 161,462.9 мянган төгрөгийн цалинг нэрийн дансанд хөтөлж, шүүхийн төлбөрт барагдуулсан 20,153.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.1 дэх заалтыг үндэслэн 2025 оны 3 дугаар сараас баривчлах байрны үйл ажиллагааг хүлээн авч, 7 орон тоо шинээр нэмэгдсэнээр цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 43.2 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4526050037

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 51 арга хэмжээ төлөвлөснийг ШШГЕГ-аас хэрэгжилтийг 88.9 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тод- руулга	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4	39,708,948.89	33,103,430.34
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		39,708,948.89	33,103,430.34
АВЛАГА	5	8,687,000.00	353,042.35
Татаас санхүүжилтийн авлага			353,042.35
Бусад авлага		8,687,000.00	
БАРАА МАТЕРИАЛ	6	251,427,451.37	369,794,910.83
Түүхий эд материал		68,496,095.33	119,574,062.19
Хангамжийн материал		182,931,356.04	250,220,848.64
Мал, амьтад		95,155,000.00	119,620,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		299,823,400.26	403,251,383.52
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	3,251,167,109.82	3,575,663,145.13
Биет хөрөнгө		2,121,573,359.82	2,446,954,395.13
Барилга, байгууламж		2,459,283,997.37	2,459,283,997.37
Хуримтлагдсан элэгдэл		701,968,178.83	820,950,934.78
Авто- тээврийн хэрэгсэл		177,926,500.00	436,380,000.00
Хуримтлагдсан элэгдэл		74,942,197.78	103,330,892.95
Машин, тоног төхөөрөмж		474,474,894.82	577,173,035.79
Хуримтлагдсан элэгдэл		278,760,858.31	170,960,287.29
Тавилга, аж ахуйн эд хогшил		114,443,398.10	83,937,276.10
Хуримтлагдсан элэгдэл		63,354,195.55	29,047,799.11
Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж		14,470,000.00	14,470,000.00
БИЕТ БУС ХӨРӨНГӨ		1,129,593,750.00	1,128,708,750.00
Программ хангамж		6,310,000.00	5,310,000.00
Хуримтлагдсан элэгдэл		4,466,250.00	4,351,250.00
Бусад		1,127,750,000.00	1,127,750,000.00
БУСАД ХӨРӨНГӨ	8		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,251,167,109.82	3,575,663,145.13
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,550,990,510.08	3,978,914,528.65
Богино хугацаат өр төлбөр		37,355,906.54	39,663,978.79
Өглөг	9	37,355,906.54	39,663,978.79
Ажиллагчидтай холбогдсон өглөг			5,381.59
Байгууллагад өгөх өглөг		150,000.00	1,881,000.00
Хувь хүмүүст өгөх өглөг		37,205,906.54	37,777,597.20
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН			
Засгийн газрын хувь оролцоо		3,513,634,603.54	3,939,250,549.86
Засгийн газрын оруулсан капитал		1,624,921,893.90	1,624,921,893.90
Хуримтлагдсан үр дүн		(71,166,901.26)	354,449,045.06
Өмнөх үеийн үр дүн		(71,166,901.26)	(71,166,901.26)
Тайлант үеийн үр дүн			425,615,946.32
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,959,879,610.90	1,959,879,610.90
Хяналтын бус хувь оролцоо			
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		3,513,634,603.54	3,939,250,549.86
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		3,550,990,510.08	3,978,914,528.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</u>	<u>2</u>	3,412,480,416.57	5,211,770,737.16
12	<u>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</u>		463,092,881.57	957,282,137.16
120	<u>Нийтлэг татварын бус орлого</u>		463,092,881.57	957,282,137.16
120004	<u>Төсөв байгууллагын өөрийн орлого</u>		463,092,881.57	951,837,622.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		284,989,947.17	262,111,155.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		178,102,934.40	689,726,466.57
120005	Түрээсийн орлого		-	5,444,515.00
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>		2,949,387,535.00	4,254,488,600.00
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс</u>		2,895,510,500.00	4,229,488,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,895,510,500.00	4,229,488,600.00
1311	<u>Нэмэлт санхүүжилтийн орлого</u>		53,877,035.00	25,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		42,880,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00	25,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		997,035.00	-
II	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</u>	<u>3</u>	3,550,873,316.81	4,786,154,790.52
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ</u>		3,550,873,316.81	4,786,154,790.52
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</u>		3,333,834,969.64	4,311,712,192.97
21	<u>ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ</u>		2,310,227,557.29	3,308,950,816.30
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</u>		2,263,854,800.00	3,238,596,784.90
210101	Үндсэн цалин		1,259,036,671.51	1,944,229,381.59
210102	Нэмэгдэл		824,341,528.49	1,048,286,003.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт		122,934,000.00	246,081,400.00
210104	Урамшуулал		57,542,600.00	-
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</u>		46,372,757.29	70,354,031.40
210201	Тэтгэврийн даатгал		600,000.00	5,721,855.48
210202	Тэтгэмжийн даатгал		80,000.00	613,049.95
210203	ҮОМШӨ-ний даатгал		35,000.00	306,524.98
210204	Ажилгүйдлийн даатгал		30,000.00	272,469.73
210205	Эрүүл мэндийн даатгал		45,627,757.29	63,440,131.26
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</u>		169,546,907.46	215,721,862.13
210301	Гэрэл, цахилгаан		83,689,406.87	111,500,952.55
210302	Түлш, халаалт		68,258,900.00	80,634,941.71
210303	Цэвэр, бохир ус		17,598,600.59	23,585,967.87

2104	<u>Хангамж, бараа материалын зардал</u>		163,733,496.74	110,083,732.63
210401	Бичиг хэрэг		4,259,830.00	7,466,500.00
210402	Тээвэр, шатахуун		38,457,000.00	38,703,885.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр		3,239,099.39	3,634,404.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		171,200.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		689,498.97	15,312,293.40
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		59,421,638.91	41,831,650.00
210408	Бараа материал акталсны зардал		57,495,229.47	2,955,000.00
2105	<u>Нормативт зардал</u>		309,175,276.96	331,758,283.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		5,178,073.00	16,157,410.89
210502	Хоол, хүнс		302,928,425.26	315,600,872.25
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,068,778.70	-
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал</u>		59,312,215.00	72,675,360.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		815,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		1,645,000.00	561,710.00
210604	Урсгал засвар		56,852,215.00	72,113,650.00
2107	<u>Томилолт, зочны зардал</u>		500,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт		500,000.00	1,000,000.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</u>		28,793,028.51	8,545,607.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		21,209,995.51	4,363,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		330,533.00	504,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		198,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,840,500.00	839,500.00
210807	Газрын төлбөр		2,214,000.00	2,838,687.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал</u>		292,546,487.68	262,976,531.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		37,685,720.35	36,280,689.61
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		254,860,767.33	226,695,842.16
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>		217,038,347.17	474,442,597.55
2132	<u>Бусад урсгал шилжүүлэг</u>		109,263,000.00	337,356,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		74,497,000.00	315,010,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		34,766,000.00	22,346,000.00
2133	<u>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</u>		-	95,290,243.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	95,290,243.15
2135	<u>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</u>		107,775,347.17	41,795,554.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		107,775,347.17	40,259,554.40
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		-	1,536,000.00

22	<u>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</u>		-	-
III	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</u>		(138,392,900.24)	425,615,946.64
IV	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</u>		-	-
V	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</u>		39,416,666.84	0.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		39,416,666.84	0.32
VI	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</u>		(177,809,567.08)	425,615,946.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</u>	3,603,280,517.70	4,826,514,341.36
12	<u>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</u>	653,892,982.70	572,025,741.36
120	<u>Нийтлэг татварын бус орлого</u>	653,892,982.70	572,025,741.36
120004	<u>Төсөв байгууллагын өөрийн орлого</u>	649,654,440.35	566,581,226.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	649,654,440.35	566,581,226.36
120005	Түрээсийн орлого	3,840,000.00	5,444,515.00
120009	Бусад орлого	398,542.35	-
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	2,949,387,535.00	4,254,488,600.00
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс</u>	2,895,510,500.00	4,229,488,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,895,510,500.00	4,229,488,600.00
1311	<u>Нэмэлт санхүүжилтийн орлого</u>	53,877,035.00	25,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,880,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	25,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	997,035.00	-
2	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</u>	3,552,669,396.28	4,828,097,259.91
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ</u>	3,552,669,396.28	4,828,097,259.91
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</u>	3,327,010,049.11	4,357,657,620.01
21	<u>ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ</u>	2,310,293,600.00	3,308,945,434.71
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</u>	2,263,854,800.00	3,238,591,403.31
210101	Үндсэн цалин	1,259,036,671.51	1,944,224,000.00
210102	Нэмэгдэл	824,341,528.49	1,048,286,003.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	122,934,000.00	246,081,400.00
210104	Урамшуулал	57,542,600.00	-

2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</u>	46,438,800.00	70,354,031.40
210201	Тэтгэврийн даатгал	600,000.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	80,000.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,000.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	30,000.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	45,693,800.00	70,354,031.40
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</u>	169,850,135.00	211,928,346.55
210301	Гэрэл, цахилгаан	83,797,035.00	110,415,980.51
210302	Түлш, халаалт	68,453,100.00	76,853,426.13
210303	Цэвэр, бохир ус	17,600,000.00	24,658,939.91
2104	<u>Хангамж, бараа материалын зардал</u>	47,490,300.00	55,123,953.23
210401	Бичиг хэрэг	3,300,000.00	5,046,850.00
210402	Тээвэр, шатахуун	38,280,000.00	44,310,500.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,239,100.00	3,463,003.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,200.00	470,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	1,833,600.00
2105	<u>Нормативт зардал</u>	288,000,000.00	327,629,665.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,000,000.00	18,793,120.00
210502	Хоол, хүнс	282,000,000.00	308,836,545.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал</u>	79,282,295.00	69,349,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,822,295.00	1,525,500.00
210602	Тавилга	180,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,000,000.00	1,839,580.00
210604	Урсгал засвар	65,280,000.00	65,984,500.00
2107	<u>Томилолт, зочны зардал</u>	500,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	1,000,000.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</u>	376,153,719.11	309,664,502.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	368,431,219.11	305,481,995.69
210804	Тээврийн хэрэгслийн татвар	470,000.00	504,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,840,500.00	839,500.00
210807	Газрын төлбөр	2,214,000.00	2,838,687.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал</u>	55,440,000.00	74,016,137.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,440,000.00	74,016,137.83

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,659,347.17	470,439,639.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	109,263,000.00	333,000,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74,497,000.00	315,010,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,766,000.00	17,990,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	95,643,285.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	95,290,243.15
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	353,042.35
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	116,396,347.17	41,795,554.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	116,396,347.17	41,795,554.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	50,611,121.42	(1,582,918.55)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,245,705.00	5,022,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,245,705.00	5,022,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,245,705.00	5,022,600.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,245,705.00	5,022,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(37,245,705.00)	(5,022,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	13,365,416.42	(6,605,518.55)
9	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	26,343,532.47	39,708,948.89
10	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	39,708,948.89	33,103,430.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,624,921,893.90	1,959,879,610.90	106,642,665.82	3,691,444,170.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,624,921,893.90	1,959,879,610.90	106,642,665.82	3,691,444,170.62
Тайлант үеийн үр дүн	-	-	(177,809,567.08)	(177,809,567.08)
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,624,921,893.90	1,959,879,610.90	(71,166,901.26)	3,513,634,603.54
Залруулсан үлдэгдэл	1,624,921,893.90	1,959,879,610.90	(71,166,901.26)	3,513,634,603.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-

Тайлант үеийн үр дүн	-	-	425,615,946.32	425,615,946.32
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,624,921,893.90	1,959,879,610.90	354,449,045.06	3,939,250,549.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
13	<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	4,357,634,900.00	4,134,198,356.85	223,436,543.15	94.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,357,634,900.00	4,134,198,356.85	223,436,543.15	94.9
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,357,634,900.00	4,134,198,356.85	223,436,543.15	94.9
120	<u>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</u>		5,444,515.00		100.0
120005	Төрийн өмч түрээслүүлсний орлого		5,444,515.00	-	100.0
120005	Түрээсийн орлого		5,444,515.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	244,646,900.00	228,156,152.47	16,490,747.53	93.3
1	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</u>	4,602,281,800.00	4,367,799,024.32	234,482,775.68	94.8
	<u>Ажиллагчидтай холбогдсон зардал</u>	3,448,179,400.00	3,238,591,403.31	209,587,996.69	
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</u>	3,448,179,400.00	3,238,591,403.31	209,587,996.69	93.9
210101	Үндсэн цалин	1,944,098,000.00	1,944,224,000.00	(126,000.00)	100.0
210102	Нэмэгдэл цалин	1,258,000,000.00	1,048,286,003.31	209,713,996.69	83.3
210103	Унаа хоолны нэмэгдэл	246,081,400.00	246,081,400.00	-	100.0
2102	<u>Нийгмийн хамгааллын шимтгэл</u>	70,933,000.00	70,354,031.40	578,968.60	99.2
210205	Эрүүл мэндийн даатгал	70,933,000.00	70,354,031.40	578,968.60	99.2
	<u>Бараа, үйлчилгээний урсгал зардал</u>				
2103	<u>Тогтмол зардал</u>	213,150,300.00	211,928,346.55	1,221,953.45	99.4
210301	Гэрэл, цахилгаан	110,537,100.00	110,415,980.51	121,119.49	99.9
210302	Түлш, халаалт	78,551,100.00	76,853,426.13	1,697,673.87	97.8
210303	Цэвэр, бохир ус	24,062,100.00	24,658,939.91	(596,839.91)	102.5
	<u>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</u>	331,770,500.00	327,629,665.00	4,140,835.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,933,300.00	18,793,120.00	4,140,180.00	82.0
210502	Хоол, хүнс	308,837,200.00	308,836,545.00	655.00	100.0
	<u>Бусад, бараа үйлчилгээний зардал</u>	217,891,800.00	198,272,178.06	19,619,621.94	
210401	Бичиг хэрэг	4,788,800.00	5,046,850.00	(258,050.00)	105.4
210402	Тээвэр, шатахуун	45,142,100.00	44,310,500.00	831,600.00	98.2
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,770,100.00	3,463,003.23	307,096.77	91.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	470,000.00	470,000.00		100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,995,400.00	1,833,600.00	161,800.00	91.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,666,800.00	1,525,500.00	15,141,300.00	9.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,991,200.00	1,839,580.00	1,151,620.00	61.5
210604	Урсгал засвар	66,000,000.00	65,984,500.00	15,500.00	100.0

210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00		100.0
210801	Бусад нийтлэг АҮТ хураамж	4,625,000.00	4,750,000.00	(125,000.00)	102.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	504,400.00	504,320.00	80.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	197,100.00		197,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	840,000.00	839,500.00	500.00	99.9
210807	Газрын төлбөр	2,838,700.00	2,838,687.00	13.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,062,200.00	63,866,137.83	2,196,062.17	96.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	315,010,800.00	315,010,800.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,346,000.00	990,000.00	4,356,000.00	18.5
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,022,600.00	(5,022,600.00)	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг-Төсөвт байгууллага	-	259,554.40	(259,554.40)	-
I	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,602,281,800.00	4,367,799,024.32	234,482,775.68	94.9
	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		39,708,948.89		-
	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		33,103,430.34		-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,878.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажиллах 2 зөвлөмж хүргүүллээ.

3.1 Зөвлөмж

3.1.1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын дотоод журмаар олгодог урамшууллыг түр зогсоосон байхад албан хаагч нарт гүйцэтгэлийн төлөвлөгөөг маш сайн дүгнүүлсэн Хөдөлмөрийн аварга, шилдэг офицер, шилдэг ахлагч, тэргүүний ажилтан, оны шилдэг ажилтнуудад урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4.2-т “байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлангийн “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан тогтоол, шийдвэрийг мөрдөж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулах,

3.1.2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлангийн “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулах

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотоод журмаар олгодог мөнгөн шагнал, урамшууллыг түр зогсоосон байхад шагнал олгосон	1	17,938.1	-	-	-	-	1	17,938.1	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон байхад ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд урамшуулал олгосон	1	5,940.0					1	5,940.0				
Дүн	2	23,878.1	-	-	-	-	2	23,878.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 3 гүйлгээг мэдээлээгүй байна	1	23,235.0	-	-	-	-	1	23,235.0
Дүн	1	23,235.0	-	-	-	-	1	23,235.0